

“БҮХ НИЙТИЙН АНГЛИ ХЭЛНИЙ СУРАЛЦАХУЙГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭ (2022-2025)”

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН АНГЛИ ХЭЛНИЙ БАГШИЙН АНГЛИ ХЭЛНИЙ ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ОНОШЛОХ СУДАЛГАА (Needs Analysis) ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗААВАРЧИЛГАА

Нэг. Нийтлэг үндэслэл.

- 1-1. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга хэмжээг батлах тухай” 372 дугаар тогтоол, Боловсрол, Шинжлэх Ухааны Сайдын А/145 тоот тушаалыг хэрэгжүүлэх үндэслэл болно.
- 1-2. Төрийн-өмчит ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний багшийн англи хэлний түвшинг тогтоох оношлох судалгааг зохион байгуулахад энэхүү зааварчилгааг мөрдөнө.

Хоёр. Зорилго.

- 2-1. Үндэсний хэмжээнд англи хэлний боловсролын тогтолцоог хөгжүүлэх, ерөнхий боловсролын түвшинд англи хэлний сургалтын чанар, үр дүнг сайжруулах;
- 2-2. Ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний багшийг чадавхжуулах, мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг төлөвлөх, зохион байгуулахад зориулсан суурь өгөгдөл мэдээлэл бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

Гурав. Ерөнхий мэдээлэл

- 3-1. Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэн (БСҮХ)-ийн Гадаад хэлний төвөөс оношлох судалгаа зохион байгуулах зааварчилгааг боловсруулахад Боловсролын Ерөнхий Газар (БЕГ)-тай хамтарч ажиллана.
- 3-2. Багш нарын түвшин тогтоох оношлох судалгааг Боловсролын Ерөнхий Газар хариуцан Боловсрол, Шинжлэх Ухааны Газар (БШУГ), Боловсролын хэлтсүүд зохих бэлтгэлийг хангаж, шалгалт эхлэхээс өмнө урьдчилан гаргасан хуваарийн дагуу цахимаар зохион байгуулна.
- 3-3. Орон нутагт аймгийн БШУГ-ууд, нийслэлд дүүргийн боловсролын хэлтсүүд харьяалагдах ЕБС-ийн англи хэлний багш нарын холбогдох утас, цахим хаягтай мэдээлэл, оношлох судалгаа зохион байгуулах байр зэргийг бэлтгэж оношлох судалгаа эхлэхээс 7 хоногийн өмнө бэлтгэл ажлыг хангасан байна.
- 3-4. БЕГ-ын Багшийн цахим кампус сургалтын системд нэвтрэх, бүртгүүлэхтэй холбоотой бэлтгэлийг ерөнхий боловсролын сургуулийн удирдлагууд хариуцан өөрийн сургуулийн багш нарын оношлох судалгаанд саадгүй

- хамрагдах бэлтгэлийг хангасан эсэхийг нягталж холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.
- 3-5. Багш нарын түвшин тогтоох оношлох судалгааны дүнг зохих шаардлагын дагуу нууцалж зөвхөн сургалт зохион байгуулах албан хэрэгцээнд ашиглана.
 - 3-6. Оношлох судалгааны үр дүнг тухайн багшид \өөрийн хүсэлтэд үндэслэн\ албан ёсоор мэдэгдэнэ.
 - 3-7. Оношлох судалгаа авах товлосон цаг хугацаа дуусснаас хойш ирсэн багшийг судалгаанд хамруулахгүй.
 - 3-8. Оношлох судалгаа зохион байгуулагдах үед газар хөдлөх, үерт автах, гал түймэр гарах зэрэг байгалийн давагдашгүй хүчин зүйл тохиолдож эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх ба шаардлагатай гэж үзвэл төлөвлөгөөт ажлыг шууд цуцлана.
 - 3-9. Хувь хүнтэй холбоотой асуудлууд буюу хүнд өвдөх, уй гашуу тохиолдох, гэмтэж бэртэх зэрэг хүндэтгэх шалтгаан гарсан тохиолдолд тухайн багшийн гаргасан нотлох баримтад үндэслэн тухайн үед нь зохих хариу арга хэмжээ авна.
 - 3-10. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн\багш оношлох судалгаанд хамрагдах бол таяг, тэргэнцэр, брайль үсэгтэй хэвлэмэл материал зэрэг тохирох хэрэглэгдэхүүн, харааны бэрхшээлтэй иргэнд уг оношлох судалгааг сонсоод гүйцэтгэхээр болгох, үг үсгийг томруулж харуулах зэрэг тохируулга хийх, дохионы хэлмэрч, хөтөч ажиллуулах, шаардлагатай гэж үзвэл тусгай өрөө гаргах зэрэг бэлтгэл ажлыг хангасан байна.
 - 3-11. Оношлох судалгааны материалыг мэргэжилтнүүд урьдчилан бэлдэж, мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтнүүд цахим системд байршуулна.

Дөрөв. Оношлох судалгаа зохион байгуулах

- 4-1. Багш нарын түвшин тогтоох оношлох судалгаа зохион байгуулах тухай мэдээллийг багшид хувийн бэлтгэл, цагийн хуваарилалтын баримжааг олгох зорилгоор урьдчилан цахим системд нээлттэй байршуулна.
- 4-2. Оношлох судалгааг цахимаар зохион байгуулахтай холбоотой шаардагдах техникийн бэлтгэлийг БЕГ-ын холбогдох мэргэжилтнүүд ба бусад холбогдох байгууллагууд бүрэн хангасан байна.
- 4-3. Оношлох судалгааны материалын нууцлалыг судалгааг зохион байгуулахад оролцож байгаа мэргэжилтнүүд хариуцна.
- 4-4. Англи хэлний багш нарын түвшин тогтоох оношлох судалгааг БЕГ-аас хариуцан зохион байгуулж үр дүнг нэгтгэнэ.
- 4-5. Багш нарын оношлох судалгааг цахимаар зохион байгуулах бөгөөд интернэт орчинд суурин болон зөөврийн компьютер дээр ажиллаж товлосон өдөр, цагт багш нар оношлох судалгаанд хамрагдана.

- 4-6. Чимээ шуугиан багатай, тохиромжтой гэрэлтүүлэг, дулаан\сэрүүцүүлэгчтэй анги танхимыг бэлдэж оношлох судалгаанд хамрагдаж байгаа багш нарт судалгаа эхлэх, дуусах цагийг урьдчилж зарласан байна.
- 4-7. Аймгийн БШУГ ба дүүргийн боловсролын хэлтсийн удирдлагууд, мэргэжилтнүүд оношлох судалгааг удирдан зохион байгуулах талаар холбогдох менежер, ажилтнуудад нарийвчилсан зааварчилгааг өгнө.
- 4-8. Анги танхимд оношлох судалгаа зохион байгуулж байгаа хүмүүс техник технологи, зохион байгуулалтын доголдол, судалгаанд оролцогчдын хандлага үйлдэл болон оношлох судалгаа зохион байгуулсан тухай харьяалагдах удирдлагууд, мэргэжилтнүүдэд товч тодорхой мэдээлж, тайлагнана.
- 4-9. Багшийн оношлох судалгаа зохион байгуулахад ширээн дээр элдэв зүйлс байрлуулахгүй. Ирцийн бүртгэлийн дагуу багш нарыг бүртгэж, шаардлагатай тохиолдолд иргэний үнэмлэхийг шалгаж тулгана.
- 4-10. Оношлох судалгаа эхлэхээс өмнө компьютер, техник, интэрнэт, чихэвч, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг шалгаад багш нарт холбогдох зааварчилгааг өгнө.
- 4-11. Өрөөнд байгаа ажиглагчид оношлох судалгааны агуулга дээр багшид хандан санал хэлэхийг хориглоно. Ариун цэврийн өрөө орох хүсэлтэй багшийг коридорт байгаа нэмэлт ажиглагчийн хяналттайгаар оруулна.
- 4-12. Хэт чанга ярих, бусдад саад болох зэргээр зааварчилгаа дагахгүй байгаа оролцогчдод шалгалтын зааварчилгаа мөрдөхийг сануулна.
- 4-13. Оношлох судалгаа дуусахаас 5 минутын өмнө цаг дуусч байгааг сануулна.
- 4-14. Оношлох судалгаанд оролцогч багш бусад оролцогчийн хийж байгааг харж ажиглах, хуулах оролдлого хийх боломжгүй байхаар хоорондын зай, хаалтыг тохируулна.
- 4-15. Оношлох судалгааг зохион байгуулагчид хэт өндөр өсгийтэй гутал өмсөж чимээ гаргахаас зайлсхийх, хэт олон өнгийн чимэглэлтэй хана – тохижилттой ангид зохион байгуулахаар бол чимэглэлийг бууруулж оролцогчдын анхаарал сарнихгүй байхад анхаарах, англи хэлний дүрэм, агуулгатай ханыг халхлах зэрэг арга хэмжээ авна.
- 4-16. Судалгаанд оролцогчдыг \хэт гялгар, гэрэлтдэг хувцас, содон аксессуар гэх мэт\ бусдын анхаарал сарнихаар зохисгүй хувцаслахгүй байхыг зөвлөж, сануулна.

Тав. Оношлох судалгааны зохион байгуулалттай холбоотой бусад асуудлууд

- 5-1. Англи хэлний багш нар оношлох судалгаа эхлэхээс 20-25 минутын өмнө ирж судалгаанд хамрагдах бэлтгэлээ хангаж техник төхөөрөмж, интернетийн холболтыг туршиж бэлэн байдлаа хангасан байна.
- 5-2. Багш нар цахимаар судалгаанд оролцохдоо чимээгүй орчинд, бусдын оролцоогүйгээр, өөрийн биеэр шалгалтаа өгнө.

- 5-3. Сумын сургуулийн багш нар аймгийн төвд очиж оношлох судалгаанд хамрагдах ба тухайн аймгийн Боловсрол, Шинжлэх Ухааны Газар оношлох судалгаа авах байр, ажиллах хүмүүсийг хуваарилж бусад холбогдох \хүртээмжтэй холбоотой гэх мэт\ зохицуулалтуудыг хийж удирдлагаар хангаж ажиллана.
- 5-4. Нийслэлд дүүргийн боловсролын хэлтсүүд ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний багшийн оношлох судалгааг зохион байгуулж, удирдлагаар хангана. Дүүргийн боловсролын хэлтсүүд ерөнхий боловсролын сургуулиудын үнэлгээ хариуцсан менежерүүдийг өөрийн сургууль дээр бус, ойролцоо өөр сургууль дээр оношлох судалгаа авахаар \сольж ажиллуулах\ зохицуулалт хийнэ.
- 5-5. БЕГ-ын мэдээлэл, технологийн мэргэжилтнүүд оношлох судалгааны хяналтын системийг тавигдах шаардлагын дагуу бүрдүүлж, техник технологи, цахим шалгалтын бэлтгэлийг бүрэн хангасан байна.
- 5-6. Анги танхимд оношлох судалгаа зохион байгуулж байгаа хүмүүс анхааралтай, сонор сэрэмжтэй ажиглаж, анги дотуур чимээ гаргалгүй явж хяналт тавина. Нэг ажиглагч 15-20 хүн хариуцаж ажиллахаар зохицуулалт хийнэ.
- 5-7. Оношлох судалгаа хариуцан ажиллаж байгаа мэргэжилтнүүдэд хүндэтгэн үзэх шалтгаан гарсан тохиолдолд холбогдох удирдлагын зүгээс чөлөө олгох, оронд нь өөр ажилтан томилж ажиллуулж болно.
- 5-8. Оношлох судалгааны материалын нууцлал, багшийн кодыг байгууллагуудын холбогдох мэргэжилтнүүд хариуцна.
- 5-9. Оношлох судалгааны бүртгэл ба судалгаанд хамрагдсан мэдээлэлд үндэслэн багш нарт замын зардал олгох ажлыг БЕГ, БШУГ-ын мэргэжилтнүүд хамтран зохион байгуулна.
- 5-10. Тэтгэвэрт гарах нас \1-3 жил дутуу\ ойртсон; хүүхэд асрах чөлөөтэй байгаа зэрэг хүндэтгэн үзэх шалтгааныг харгалзах бол тухайн багшийн бичгээр гаргасан хүсэлт, хүсэлтийг нотолсон сургуулийн удирдлагын албан бичигт үндэслэн, IELTS, TOEFL, ТКТ зэрэг олон улсын түвшний англи хэлний шалгалтын стандарт оноотой; гадаадад баклавр, мастер, докторын зэрэг англи хэлээр хамгаалсан багш нарыг холбогдох нотлох бичиг баримтыг үндэслэн оношлох судалгаанаас тус тус чөлөөлж болно.
- 5-11. Олон улсын түвшний англи хэлний шалгалтын стандарт оноо гэдэгт IELTS 6.0 оноо \ба түүнээс дээш\ болон түүнтэй дүйцэхүйц бусад шалгалтын оноог тооцно.
- 5-12. Ажиглагчид танхимд байгаа оношлох судалгаа гүйцэтгэхэд ашиглагдах компьютер, нэмэлт төхөөрөмжөөс бусад бүх гар утас, интернэтд холбогддог төхөөрөмжүүдийг оношлох судалгаа эхлэхээс өмнө унтраан хурааж авна. Оношлох судалгаа дууссны дараа бүх судалгаанд оролцогчдыг танхимд байлгаж \гарч явахгүй байхыг сануулсны үндсэн дээр\ утас, бусад зүйлсийг эзэнд нь эргүүлж өгнө.

Зургаа. Үүрэг хариуцлага

- 6-1 Байгууллагууд багш нарын англи хэлний түвшин тогтоох оношлох судалгаа зохион байгуулахтай холбоотой бичгээр\цахимаар ирсэн тодорхой мэдээлэл, албан ёсны шийдвэрийг дагаж мөрдөнө.
- 6-2 Байгууллагууд англи хэлний багшийн оношлох судалгааг хамтран зохион байгуулах талаар мэргэжилтнүүд, менежерүүд, ажиглагч нарыг удирдлагаар ханган дэмжлэг туслалцаа үзүүлж ажлаа явуулах боломжоор бүрэн хангана.
- 6-3 Байгууллагууд оношлох судалгаа зохион байгуулахад холбогдох мэргэжилтнүүд болон бусад ажилтнуудыг удирдлагаар ханган дэмжлэг туслалцаа үзүүлээгүй, ажлаа явуулах боломж бололцоог хязгаарлаж, аливаа саад бэрхшээл учруулсан албан тушаалтанд холбогдох зөрчлийг харъяалах дээд байгууллагад мэдээлнэ.
- 6-4 Энэхүү журамд тодорхой заагдаагүй зүйлүүд болон аливаа маргааны шинжтэй асуудлуудыг БСҮХ болон БҮТ, БЕГ зэрэг байгууллагаас гаргасан журам, бусад баримт бичгийн зохицуулалтын хүрээнд шийдвэрлэнэ.
- 6-5 Англи хэлний багш нарын оношлох судалгаа зохион байгуулах, дүн, санал гомдолтой холбоотой бүх асуудлыг БЕГ, БСҮХ-ийн удирдлагуудын түвшинд хэлэлцэж 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.
- 6-6 Оношлох судалгааг зохион байгуулахад хариуцлагагүй хандсан, улмаар оношлох судалгааны дүн үнэн зөв гарах боломжгүй болсон, судалгаанд оролцогчдын эрх ашиг ноцтой зөрчигдсэн гэж үзсэн тохиолдолд тусгай баримтат тайлан бэлдэж Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
